



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ  
**ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ  
ГАЗАР**

Нийслэлийн засаг захиргааны IV байр,  
4 дүгээр хороо, Чингэлтэй дүүрэг,  
Улаанбаатар хот, 15160-0066  
Утас:(976) 7575 7807, Факс: (976) 7575 7809  
Цахим шуудан: [contact@ub-procurement.mn](mailto:contact@ub-procurement.mn)  
Цахим хаяг: [www.ub-procurement.mn](http://www.ub-procurement.mn)

2024.08.21 № 03/1606

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Тодруулга оруулах тухай

Тус газраас 2024 оны 07 дугаар сарын 25-ны өдөр зарласан НХААГ/20240101008 дугаартай Хороо, өрхийн эмнэлэг, цагдаагийн хэсгийн цогцолбор барилга (Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 35 дугаар хороо)-ын ажил Монгол улсын Сангийн яаманд гомдол гарсан тул Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.6 дахь заалтын дагуу тендерийн хүлээн авах эцсийн хугацааг хойшлуулсан болно. Үүнд:

Тендер шалгаруулалтын баримт бичгийн тендерийн өгөгдлийн хүснэгтэд:

- ТШЗ 26.1: Тендер хүлээн авах эцсийн хугацааг 2024 оны 09 дүгээр сарын 04-ний өдрийн 09 цаг 00 минут хүртэл
- ТШЗ 26.2: Тендер нээх хугацааг 2024 оны 09 дүгээр сарын 04-ний өдрийн 09 цаг 30 минут хүртэл болгон өөрчилснийг мэдэгдэж байна

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3-т заасны дагуу тодруулгыг цахим системд нээлттэй байршуулснаар сонирхогч этгээдэд хүргүүлсэнд тооцно.